

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ОНЦЛОГ ХЭРЭГЦЭЭНД НЬ НИЙЦСЭН
ТУСГАЙЛСАН АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ, ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГУУДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ**

Төсөл сонгон
шалгаруулалт/
гэрээний нэр:

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь
нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох аж ахуйн
нэгж, төрийн бус байгууллагуудад санхүүгийн дэмжлэг
үзүүлэх**

Төсөл сонгон
шалгаруулалт/
гэрээний дугаар:

ХБХХЕГ/20220906/

Байгууллагын регистр: 6345492

2022 он

БҮЛЭГ I.
ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА- ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ
ОНЦЛОГ ХЭРЭГЦЭЭНД НЬ НИЙЦСЭН ТУСГАЙЛСАН АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ АЖ
АХУЙН НЭГЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТӨСЛИЙН
БАРИМТ БИЧИГ

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох зорилгоор боловсруулсан санхүүгийн дэмжлэг олгох сонгон шалгаруулалт

Огноо: **2022.09.06**

Төсөл сонгон шалгаруулалтын дугаар: **ХБХХЕГ /20220906/**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох сонгон шалгаруулалтад аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудыг төслийн баримт бичиг ирүүлэхийг урьж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох төслүүд нь дор дурдсан тэргүүлэх чиглэлүүдтэй байна. Үүнд:

- 1) Үйлчилгээний салбарт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтвортой ажиллуулах үсчин, гоо сайхан, бариа засал, цайны газар, кофе шоп, оёдол, гутал засвар, гар урлал гэх мэт/
- 2) Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт /Хүнс, нарийн боов, бууз баншны үйлдвэрлэл, мужаан, модон эдлэлийн үйлдвэрлэл, сийлбэр, эсгий, эсгий эдлэл, цаасан болон даавуун уут, дугтуй гэх мэт/
- 3) Хөдөө аж ахуйн салбарт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг жимс, хүнсний ногоо тариалах, боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлд ажиллуулах, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлийн үйлдвэрлэл болон фермерийн аж ахуй эрхлэлт гэх мэт/
- 4) Мэдээллийн технологи, цахим үйлчилгээ, бүх төрлийн хэвлэлийн үйлчилгээ, дуу бичлэгийн студи гэх мэт.
- 5) Бусад гэх мэт

Сүүлийн 24 сарын хугацаанд төсөл хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын төсөл сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийг хүлээн авахгүй.

Төслийн баримт бичгийн иж бүрдлийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50.000 /тавин мянга/ төгрөгөөр худалдаж авна. Төслийн баримт бичиг худалдаж авснаар төсөл сонгон шалгаруулалтад оролцох эрх үүснэ.

Төслийн баталгааны хувь хэмжээ нь 1% /нэг хувь/ байна. Төслийн баримт бичгийг хүлээж авах хүчинтэй хугацаанд ирүүлнэ.

Төслийн баримт бичгийг 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлэх бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 11.00 цагт нээнэ. Нээлтэд оролцох хүсэлтэй төсөл ирүүлсэн оролцогчдыг байлцуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 3 давхрын хурлын зааланд нээнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг дор дурдсан хаягаар авна уу.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Эрхүүгийн гудамж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Бодлогын хэрэгжилтийн газар 302 тоот,
Холбоо барих утас: 77073008

БҮЛЭГ II. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

А. Ерөнхий зүйл

- | | |
|-------------------------------|---|
| 1. Төслийн цар хүрээ | <p>1.1 Төсөл сонгон шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэнд (цаашид ТСШӨХ гэх) дурдагдсан Захиалагч нь Гэрээний хавсралт А-д тодорхойлсон үйлчилгээг үзүүлэх этгээдийг сонгохоор төсөл сонгон шалгаруулж байна. ТСШӨХ-д гэрээний нэр болон дугаарыг заасан болно.</p> <p>1.2 Шалгарсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь ТСШӨХ-д заасан хугацаанд үйлчилгээг гүйцэтгэж дуусгах үүрэг хүлээнэ.</p> |
| 2. Хөрөнгийн эх үүсвэр | <p>2.1 Захиалагч дээр дурдсан үйлчилгээг ТСШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.</p> |
| 3. Эрх бүхий оролцогч | <p>3.1 Төсөл сонгон шалгаруулалтын урилга нь эрх бүхий оролцогч бүрт нээлттэй.</p> <p>3.2 Дараах тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">3.2.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон3.2.2 Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;3.2.3 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;3.2.4 Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;3.2.5 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;3.2.6 Илт худал мэдээлэл бүхий төслийн материал ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;3.2.7 Сүүлийн 3 жилийн хугацаанд Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;3.2.8 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, |

техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;

3.2.9 Энэхүү төсөл сонгон шалгаруулалтад хоёр буюу түүнээс дээш тооны төсөл сонгон шалгаруулалтын оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;

3.2.10. Энэхүү төсөл сонгон шалгаруулалтын баримт бичгийн 14 дүгээр зүйлд хувилбарт төслийн материал ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн төсөл сонгон шалгаруулалтад аливаа төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нэгээс дээш төслийн материал ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш төсөл сонгон шалгаруулалтад туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг төсөл сонгон шалгаруулалтад нэгээс олон багцад төслийн материал ирүүлэхийг хязгаарлахгүй)

3.2.11.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бүтэц зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол /Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зааснаар төр ашгийн төлөө үйл ажиллагааг зөвхөн төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан явуулахаар заасан тул эдгээрээс бусад төрийн байгууллага, албан газар төсөл сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй. Энэхүү заалт Хараагүйчүүдийн улсын үйлдвэрийн газарт хамаарахгүй болно/

3.3 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч 3.2.1-3.2.11-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу төсөл сонгон шалгаруулалтад оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

4. Оролцогчийн чадвар

4.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь Бүлэг IV-т заасан Төсөл сонгон шалгаруулалтын маягт болон чадварын мэдээллийн маягтыг бөглөж, хийх ажлын аргачлалын талаарх урьдчилсан тайлбар, ажлын хуваарь, шаардлагатай бол холбогдох график зургийн хамтаар ирүүлнэ.

4.2 ТСШӨХ-д өөрөөр заагаагүй бол төсөл сонгон шалгаруулалтад оролцогч дараах мэдээлэл болон баримт бичгийг төслийн материалын хамт Бүлэг IV-т заасан маягтаар ирүүлнэ. Үүнд:

(а) Хууль эрх зүйн статус, бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, буюу үүсгэн байгуулагдсаныг тодорхойлох албан ёсны баримт бичгийн эхээс хийсэн хуулбар, тендерт оролцогчийн өмнө үүрэг хүлээж түүнийг төлөөлж төсөл сонгон шалгаруулалтад гарын үсэг зурах этгээдийн албан ёсны итгэмжлэл.

(б) Тухайн гэрээг хийж гүйцэтгэхэд шаардлагатай гол тоног

төхөөрөмжүүдийн жагсаалтыг гаргаж ирүүлэх

- (в) Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл
- (г) Тухайн төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн байдлыг харуулах ТСШӨХ-д тодорхойлсон 2020, 2021 оны жилийн санхүүгийн тайлан, баланс.

4.3 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч гэрээ байгуулах эрх олж авахын тулд дор дурдсан чадварын доод шалгуурыг хангасан байна:

- (а) Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгааг нотолсон аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй, Монгол улсын хуулийн этгээд байх
- (б) Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлсэн байнгын ажлын байр бий болгохоор тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа
- (с) Төслийг хэрэгжүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээний нөхцөл боломжоор хангагдсан байх /Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохируулгатай ажлын байр бий болгосон эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн дэвшилтэт технологи нэвтрүүлсэн байх/

- | | |
|--|--|
| 5. Нэг оролцогч нэг төслийн материал ирүүлэх | 5.1 Нэг төсөл сонгон шалгаруулалтад оролцогч зөвхөн 1 төслийн материал ирүүлнэ. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нэгээс дээш төслийн материал ирүүлсэн бол бүх төслийн материалаас татгалзана. |
| 6. Төсөл сонгон шалгаруулалтад оролцох зардал | 6.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь түүний төслийн материалыг бэлтгэх болон ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах бөгөөд ямар ч нөхцөлд эдгээр зардалтай холбогдох үүрэг хариуцлагыг захиалагч хүлээхгүй. |
| 7. Ажлын талбайтай танилцах | 7.1 Шаардлагатай үйлчилгээг үзүүлэх байршил, талбай болон түүний орчин тойрны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж судлан төслийн материал бэлтгэх, гэрээ байгуулахад шаардлагатай байж болох бүх мэдээллийг төсөл сонгон шалгаруулалтад оролцогч олж авч ашиглаж болно. Ажлын талбайтай газар дээр нь очиж танилцах зардлыг сонгон шалгаруулалтад оролцогч өөрөө хариуцна. |

Б. Төслийн баримт бичиг

- | | |
|--|--|
| 8. Төслийн баримт бичгийн агуулга | 8.1 Төслийн баримт бичгүүдийн бүрдэлд доорх жагсаалтад дурдсан баримт бичгүүд болон 10 дугаар зүйлийн дагуу гаргасан нэмэлт өөрчлөлтүүд багтана. |
|--|--|

Бүлэг II. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод өгөх зааварчилгаа

III. Төсөл сонгон шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт

- IV. Төслийн маягт болон чадварын мэдээллийн маягт
- V. Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт болон зургууд /бизнес төлөвлөгөө/
- VI. Үйл ажиллагааны хуваарь
- VII. Баталгааны маягт

- 8.2 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь төслийн баримт бичиг дахь бүх зааварчилгаа, маягтууд, нөхцөлүүд болон тодорхойлолтуудыг шалгаж нягталсан байвал зохино. Төслийн баримт бичигт ирүүлэхийг шаардсан бүх мэдээллийг дутуу ирүүлэх, эсхүл төслийн баримт бичгийг томоохон зөрүүгүй хангаж чадаагүй төслийн материал ирүүлэх нь төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн эрсдэлд хамаарах ба энэ нь түүний төслийн материалаас татгалзах үндэслэл болж болно. Бүлэг IV болон V-т холбогдох мэдээллүүдийг бөглөж ТСШӨХ-д заасан тоо хэмжээгээр хувилж олшруулан төслийн материалын хамт ирүүлнэ.
- 9. Төслийн баримт бичгийн тодруулга**
- 9.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь төслийн баримт бичгийн талаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтээ бичгээр буюу төслийн урилгад заасан захиалагчийн хаягаар тодруулга авна. Захиалагч төслийн материал ирүүлэх эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө ирүүлсэн тодруулга авах тухай аливаа хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжыг дурдалгүйгээр төслийн баримт бичиг худалдаж авсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогч бүрт хүргүүлнэ.
- 10. Төслийн баримт бичгийн нэмэлт өөрчлөлт**
- 10.1 Захиалагч, төслийн материал хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө нэмэлт хийх замаар төслийн баримт бичигт өөрчлөлт оруулж болно.
- 10.2 Ийнхүү хийсэн аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг захиалагчаас төслийн баримт бичиг худалдан авсан төсөлд оролцогч бүрт бичгээр, эсхүл утсан холбоогоор хугацаа алдалгүй мэдэгдэнэ. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 10.3 Төслийн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг төслийн материалд тусгахад нь хангалттай хугацааг төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид олгох шаардлагатай гэж захиалагч үзвэл төслийн материалыг хүлээн авах эцсийн хугацааг 19.2-т заасны дагуу сунгана.

В. Төсөл сонгон шалгаруулалтад бэлтгэх

- 11. Сонгон шалгаруулалтын хэл**
- 11.1 Төсөл сонгон шалгаруулалт, түүнчлэн төсөл сонгон шалгаруулалттай холбоотойгоор захиалагч төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр байна.
- 11.2 Аливаа төсөл сонгон шалгаруулалтын дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ

тохиолдолд тэдгээрийн Төсөл сонгон шалгаруулалтад холбогдох хэсгийг ТӨӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг төсөл сонгон шалгаруулалт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг төслийн материалыг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.

11. Сонгон шалгаруулалтын хэл

11.1 Төсөл сонгон шалгаруулалт, түүнчлэн төсөл сонгон шалгаруулалттай холбоотойгоор захиалагч төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр байна.

11.2 Аливаа төсөл сонгон шалгаруулалтын дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн Төсөл сонгон шалгаруулалтад холбогдох хэсгийг ТӨӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг төсөл сонгон шалгаруулалт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг төслийн материалыг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.

12. Төслийн материалын иж бүрдэл

12.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн ирүүлэх төслийн материал нь дараах зүйлсээс бүрдэнэ:

- (а) Төслийн маягт (Бүлэг III-т заасан маягтын дагуу);
- (б) Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт /Бизнес төлөвлөгөө/
- (г) Чадварын мэдээлэл (Бүлэг III-т заасан маягтын дагуу) болон бусад баримт бичиг;
- (д) ТСШӨХ-д тодорхойлж шаардсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлж ирүүлэх бусад материалууд.
- (е) Төслийн баталгаа
- (ё) Үнэлэгдсэн үйл ажиллагааны хуваарь

13. Төслийн үнэ

13.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь V бүлэгт заасан үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт /буюу ажлын даалгавар/-д тодорхойлсон үйлчилгээний бүх нэр төрлийг үнэлж, түүнийгээ маягтад бөглөж ирүүлнэ. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн үнийг нь тусгаж ирүүлээгүй үйлчилгээний аливаа нэр төрлийг хийж гүйцэтгэсний зардлыг захиалагч санхүүжүүлэхгүй бөгөөд үүнийг үйл ажиллагааны хуваарьт тусгагдсан бусад нэр төрлийн үйлчилгээний үнэлгээ, үнэд шингэсэн гэж үзнэ.

13.2 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь төслийн материал хүлээн авах эцсийн хугацаанаас 28 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр үйлчилгээ үзүүлэгч этгээдийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг төслийн нийт үнэд багтаасан байна.

13.3 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн дагуу шаардагдах бүх мэдээллийг төслийн материалын хамт ирүүлнэ.

14. Төсөл сонгон

14.1 Төсөл сонгон шалгаруулалт нь ТСШӨХ-д заасан хугацаанд

шалгаруулалт хүчинтэй байх хугацаа	хүчинтэй байна.
15. Төслийн баталгаа	14.2 Онцгой нөхцөл байдал үүсч төсөл сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд, захиалагч бүх оролцогчдод хандаж өөрсдийн төсөл сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацааг сунгах талаар хүсэлт гаргана. Энэхүү хүсэлт болон түүнд өгөх төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн хариу нь бичгээр, эсхүл утсан холбоогоор хийгдэнэ. 15.1 ТСШӨХ-д шаардсан тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь мөн ТСШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх төслийн баталгааг банкны байгууллагаар гаргуулан ирүүлнэ.
Г. Төслийн материал ирүүлэх	
18. Төслийн материалыг битүүмжлэх, бичиглэл хийх	18.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь төслийн материалын эх хувь болон бусад хуулбар хувиудыг тус тусад нь дугтуйд хийж битүүмжлэн “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэж бичиглэл бүхий дугтуйд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжлэн захиалагчид ирүүлнэ. 18.2. Доторх ба гаднах дугтуйнууд дараах мэдээллийг багтаасан байна. Үүнд: (а) ТСШӨХ-д дурдсан хаягаар захиалагчид хаяглана; (б) ТСШӨХ-д болон гэрээний тусгай нөхцөлд заасан гэрээний нэр, бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ; (в) ТСШӨХ-д заасан нээх хугацаанаас өмнө төслийн материалыг нээж болохгүй тухай анхааруулсан бичиглэл хийнэ. 18.3 Төслийн баримт бичгийн 20 дугаар зүйлд заасан үндэслэлээр хугацаа хоцорсон гэж зарласан тохиолдолд нээлгүй буцаах боломж бүрдүүлэх зорилгоор 18.2-т заасан мэдээллээс гадна доторхи дугтуй дээр төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр, хаягийг дурдана. 18.4 Хэрэв гаднах дугтуйг дээр заасан байдлаар битүүмжилж, бичиглэл хийгээгүй бол захиалагч уг төслийн материалыг буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл төсөл сонгон шалгаруулалт нээхээс өмнө задарсанд хариуцлага хүлээхгүй.
19. Төслийн материал хүлээн авах эцсийн хугацаа	19.1 Төслийн материалыг ТСШӨХ-д заасан хугацаанаас хоцроолгүйгээр 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлнэ. 19.2 Захиалагч 10 дугаар зүйлийн дагуу төслийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас төслийн материалыг хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр үйлчилнэ.
20. Хугацаа хоцорсон төслийн материал	20.1 Захиалагч ТООЗ-ны 19 дүгээр зүйлд тодорхойлсон төслийн материал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш хүлээж авсан аливаа төслийн материалыг “Хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж нээлгүйгээр буцаана.
21. Төслийн	21.1 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч 19 дүгээр зүйлд заасан

**материалд
нэмэлт
өөрчлөлт
хийх болон
төслийн
материалыг
буцааж авах**

төслийн материал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө бичгээр мэдэгдэл өгсний дагуу өөрийн төслийн материалд нэмэлт өөрчлөлт хийх, эсхүл өөрийн төслийн материалыг буцааж авах эрхтэй.

21.2 Төслийн материал ирүүлэх эцсийн хугацаа өнгөрсөнөөс хойш аливаа төслийн материалд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт хийж болохгүй.

21.3 Төслийн материал хүлээн авах эцсийн хугацаа болон ТСШӨХ-д заасан төсөл сонгон шалгаруулах хүчинтэй байх хугацаа, эсхүл 14.2-ын дагуу сунгасан төсөл сонгон шалгаруулах хүчинтэй байх хугацааны хооронд төслийн материалыг буцааж авах нь 15 дугаар зүйлийн дагуу төслийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

Д. Төслийн материалыг нээх, үнэлэх

**22. Төсөл сонгон
шалгаруулалтыг
нээх**

22.1 Захиалагч нь төсөл сонгон шалгаруулалтыг болон 21 дүгээр зүйлийн дагуу уг төсөл сонгон шалгаруулалтад хийгдсэн нэмэлт өөрчлөлтийг ТСШӨХ-д заасан газар, цаг хугацаанд нээнэ. Нээх үед төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн төлөөлөгч байлцах эрхтэй ба байлцсан бол төсөл сонгон шалгаруулалтын нээлтийн маягтад гарын үсэг зурна.

22.2 Эхлээд “Төслийн материалыг буцааж авах тухай” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлана. Энэ зааварчилгааны 21 дүгээр зүйлийн дагуу төслийн материалыг буцааж авах тухай мэдэгдэл ирүүлсэн үндсэн төслийн материалыг нээхгүй.

22.3 Төслийн сонгон шалгаруулалтыг нээх үед төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн нэрийг зарлаж тэмдэглэл үйлдэнэ. Хугацаа хоцорсон болон буцааж авсан төслийн материалуудыг задлалгүйгээр тухайн төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид буцааж өгнө.

22.4 Захиалагч төсөл сонгон шалгаруулалтын нээлтийн протокол, тэмдэглэл хөтлөх бөгөөд үүнд 22.3-ийн дагуу нийтэд танилцуулсан бүх мэдээллийг багтаана.

23. Нууцлах

23.1 Төсөл сонгон шалгаруулалтыг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг төсөл сонгон шалгаруулалтад оролцогч болон тухайн төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй хүнд гэрээ байгуултал задруулахыг хориглоно. Төслийн материалыг үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах явцад төсөл сонгон шалгаруулалтад оролцогчоос захиалагчид нөлөө үзүүлэх аливаа оролдлого нь түүний төслийн материалаас татгалзах үндэслэл болж болно

23.2 Хэрэв гэрээ байгуулах эрх олгогдсоны дараа төсөл сонгон шалгаруулалтад оролцогч түүний төслийн материал шалгараагүй учир шалтгааныг магадлах /тодруулах/-ыг хүсвэл энэ тухай бичгээр тайлбар авах хүсэлтээ захиалагчид тавина. Тайлбар авах тухай хүсэлт тавьсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь хуулийн 49.4 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох баримт бичиг мэдээлэлтэй танилцаж болно.

24. Төслийн материалын тодруулга

24.1.Төслийн материалыг хянан үзэх, үнэлэх болон харьцуулахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтад оролцогчоос түүний ирүүлсэн төслийн материалыг, үүний дотор үйл ажиллагааны хуваарь дахь үнийн задаргааны талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Энэ хүсэлт болон түүний хариултыг бичгээр, эсхүл утсан холбоогоор хийнэ. Гэхдээ төсөл сонгон шалгаруулалтын үнэлгээний явцад ТООЗ-ны 26 дугаар зүйлийн дагуу захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахад шаардлагатайгаас бусад тохиолдолд төслийн үнэ болон агуулгад ямар нэгэн өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй

24.2.ТООЗ-ны 24.1-д зааснаас бусад тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтад оролцогч төслийн материалыг нээснээс гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд өөрийн төслийн материалтай холбоотой аливаа асуудлаар захиалагчтай холбоо тогтоож болохгүй. Хэрэв төсөл сонгон шалгаруулалтад оролцогч Захиалагчийн мэдэгдэлд нэмэлт мэдээлэл өгөхийг хүсвэл түүнийг бичгээр ирүүлнэ.

24.3.Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчоос түүний төслийн материалыг үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох захиалагчийн шийдвэрт нөлөөлөх аливаа оролдлого нь түүний төслийн материалаас татгалзах үндэслэл болно.

25. Төслийн материалыг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

25.1.Захиалагч төслийн материалыг нарийвчлан үнэлэхээс өмнө төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь:

- (а) ТООЗ-ны 3 дугаар зүйлд заасан эрх бүхий төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн талаарх шаардлагыг хангасан эсэх;
- (б) гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэх;
- (в) төслийн материалын иж бүрдэл, төслийн материалд зохих ёсоор гарын үсэг зурсан эсэх
- (д) бүрэн төслийн материал ирүүлсэн эсэх;
- (е) төслийн баримт бичгийн үндсэн шаардлагыг хангасан төслийн материал ирүүлсэн эсэх зэргийг хянан үзнэ.

25.2. Төслийн баримт бичгийн үндсэн шаардлагыг хангасан төслийн материал гэдэг нь төслийн баримт бичгийн бүх нөхцөл, болзол болон үйлчилгээний тодорхойлолтын шаардлагыг томоохон зөрүүгүй хангасан төслийн материалыг хэлнэ. Энэ шаардлагыг биелүүлээгүй зөрүү нь дараах шинж чанартай бол түүнийг томоохон зөрүү гэж үзнэ:

- (а) Үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн үүрэгт төслийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) эдгээрийг хүлээн зөвшөөрөх нь үндсэн шаардлагыг хангасан төслийн материал ирүүлсэн бусад оролцогчийн өрсөлдөөнд шударга бус байдал үүсгэхээр бол.

25.3. Захиалагч ТООЗ-ны 25.1-д заасан шаардлагад нийцээгүй төслийн материалаас татгалзах бөгөөд энэхүү шалтгааныг үүсгэж байгаа зөрүү болон тайлбарыг засварлан төсөл сонгон

шалгаруулалтын шаардлагад нийцсэн болгож болохгүй.

- | | |
|---|--|
| 26. Алдааг залруулах | 26.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тогтоосон төслийн материалын арифметик алдаа бий эсэхийг магадлан шалгаж дараах байдлаар залруулна:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
26.2. Дээрх аргачлалын дагуу захиалагчийн залруулсан төслийн дүнг төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн зөвшөөрснөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв төсөл сонгон шалгаруулалтад оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний төслийн материалаас татгалзана. |
| 27. Төслийн материалыг үнэлэх, харьцуулах | 27.1. Захиалагч зөвхөн 25 дугаар зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоосон төслийн материалыг үнэлж, харьцуулна.

27.2. Захиалагч нь хувилбарт төслийн материалыг хүлээн зөвшөөрөхгүй. Тендерийн баримт бичгийн шаардлагыг давуулж биелүүлэх, эсхүл бусад замаар төслийн баримт бичгийн шаардлагад заагаагүй үр ашгийг захиалагчид санал болгосон өөрчлөлт, зөрүү, хувилбарт төслийн материал болон бусад хүчин зүйлсийг захиалагч төсөл сонгон шалгаруулалтын үнэлгээнд харгалзахгүй.
27.3. Шаардлагад нийцсэн төслийн материалд үнэлгээ хийнэ. Ажлын байр бий болгох хамгийн бага үнэ болон үйлчилгээний оновчтой хэлбэр санал болгосон төслийн материалд хамгийн сайн үнэлэгдсэн төслийн материал гэж үнэлнэ. |
| 28. Дотоодын төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн давуу эрх | 28.1. Дотоодын төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод аливаа давуу эрхийн зөрүү тооцохгүй. |

Е. Гэрээ байгуулах эрх олгох

- | | |
|--|--|
| 29. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур | 29.1. Захиалагч нь шаардлагад нийцсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжийн бизнесээ өргөжүүлэх, шинээр тохируулгатай ажлын байр бий болгох тухай, мөн бусад аж ахуйн нэгжийн шинээр тохируулгатай ажлын байр бий болгож хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тогтвортой ажиллуулах тухай боловсруулсан төслийг шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, анх удаа орж байгаа бол 30.0 хүртэл сая төгрөгийг 36 сарын хугацаатай, гэрээний үүргээ биелүүлсэн давтан орж байгаа бол 50.0 хүртэл сая төгрөгийг 48 сарын хугацаатай санхүүгийн дэмжлэгийг 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгөөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах чиглэлээр байнгын үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын боловсруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмшүүлэх зорилготой, төрийн бус байгууллагынхаа үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгож, тогтвортой ажиллуулах тухай төслийг сонгон шалгаруулж, барьцаагүй, хүүгүй 20 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийн эргэн төлөх нөхцөлтэйгөөр 36 сарын хугацаатайгаар санхүүгийн дэмжлэг олгох ба шалгарсан тендерт оролцогчид ТООЗ-ны дагуу гэрээ байгуулах эрх олгоно; |
|--|--|

29.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох төслүүд нь дор дурдсан тэргүүлэх чиглэлүүдтэй байна. Үүнд:

- 1) Үйлчилгээний салбарт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтвортой ажиллуулах үсчин, гоо сайхан, бариа засал, цайны газар, кофе шоп, оёдол, гутал засвар, гар урлал гэх мэт/
- 2) Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт /Хүнс, нарийн боов, бууз баншны үйлдвэрлэл, мужаан, модон эдлэлийн үйлдвэрлэл, сийлбэр, эсгий, эсгий эдлэл, цаасан болон даавуун уут, дугтуй гэх мэт/
- 3) Хөдөө аж ахуйн салбарт /Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг жимс, хүнсний ногоо тариалах, боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлд ажиллуулах, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлийн үйлдвэрлэл болон фермерийн аж ахуй эрхлэлт гэх мэт/
- 4) Мэдээллийн технологи, цахим үйлчилгээ, бүх төрлийн хэвлэлийн үйлчилгээ, дуу бичлэгийн студи гэх мэт.
- 5) Бусад гэх мэт

30. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, гэрээнд гарын үсэг зурах

30.1.Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг төсөл сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө гаргаж шалгарсан оролцогчид бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд энэ талаар бусад төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажил үйлчилгээ, бий болгох ажлын байр, олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон төслийн үнэ байна.

30.2.Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно.

30.3.Төслийн баримт бичигт заасан гэрээний маягт, нөхцөл нь Захиалагч болон шалгарсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн хоорондын бүх тохиролцоог илэрхийлэх бөгөөд Захиалагч түүнийг гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид илгээнэ.

30.4.Шалгарсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТСШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

30.5. Хэрэв гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл гарснаас хойш аливаа төсөл сонгон шалгаруулалтад оролцогч түүний төслийн материал шалгараагүй үндэслэлийг тодруулахыг хүсвэл энэ тухай хүсэлтээ захиалагчид бичгээр гаргана. Захиалагч энэ хүсэлтийн хариуг тухайн төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид даруй өгнө.

БҮЛЭГ III. ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТСШӨХ)

Энэ бүлгийн мэдээллийг захиалагч төслийн баримт бичгийг бэлтгэхдээ заавал бөглөж оруулах хэрэгтэй.

Захиалагч тухайн үйлчилгээний цар хүрээ, хэмжээ, онцлог байдлыг харгалзан төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн ерөнхий, санхүүгийн болон техник, болон боловсон хүчний талаар шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож ТСШӨХ-д тусгана. Ингэхдээ үндэслэл муутайгаар хэт өндөр шалгуур эсхүл тодорхой этгээдийн чадварт тухайлан нийцүүлэх зорилгоор тогтоон сонирхсон этгээдийн өрсөлдөөнд оролцох боломжийг хязгаарлаж болохгүй гэдгийг анхаарах ёстой.

Энд оруулсан мэдээлэл нь төслийн урилгад оруулсан мэдээлэлтэй зөрчилдөх ёсгүй.

Хаалтанд байгаа тоо нь төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод өгөх зааварчилгааны холбогдох зүйлийн дугаарыг заана.

- (1.1) Захиалагч гэж: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
- Гэрээний нэр болон дугаар нь: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- ХБХХЕГ/20220906/**
- (1.2) Дуусгахаар төлөвлөсөн хугацаа нь: 2022 оны 11 сарын 07
- (2.1) Захиалагч дээр дурдсан төслийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- (3.1) ТББ-ын 4.2 дахь хэсэгт заасны дагуу төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдоос шаардсан мэдээлэлийг дараах байдлаар өөрчлөнө.
- (4.1) 2021 оны байдлаар төсөл сонгон шалгаруулалтад оролцогчтой холбоотой гарсан шүүхийн аливаа зарга маргааны талаарх мэдээлэл, маргааны тоо /маргаан гарсан болон маргаан гараагүй талаарх албан ёсны мэдэгдэл, шүүхийн тодорхойлолт/ 2019-2021 онд ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн байнгын ажлын байр бий болгох төсөл сонгон шалгаруулалтад оролцож үүргээ биелүүлээгүй төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж 2022 оны төсөл сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй болно.
- (4.3) ТББ-ын 4.3 дахь хэсэгт шаардсаны дагуу төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдоос шаардсан чадварын мэдээлэл буюу өгөгдлүүдийг дараах байдлаар өөрчлөнө: өөрчлөгдөөгүй
- (4.4) ТББ-ын 4.4 дэх хэсэгт дурдсан төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод тавигдах чадварын шалгуур үзүүлэлт нь дараах байдлаар өөрчлөгдөж байна: өөрчлөгдөөгүй
- (5.1) Бэлтгэж ирүүлэх төслийн материалын хуулбар хувь нь: 1 ширхэг байна.
- (6.1) Төслийн материалын хэл: *Монгол хэл дээр байна.*

- (6.2) Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн бусад нэмэлт баримт материал ирүүлэх шаардлагатай гэж захиалагч үзвэл түүний жагсаалтыг оруулна.
- (6.3) Төслийн баталгааны хувь хэмжээ нь 1% /нэг/ байна.
- (7.1) Төслийн материал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш төсөл сонгон шалгаруулалт нь 31 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- (8.1) Төслийн материалын хүлээн авах захиалагчийн хаяг нь: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Эрхүүгийн гудамж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Бодлогын хэрэгжилтийн газар 302 тоот, Холбоо барих утас: 77073008
- (9.1) Төслийн материал хүлээн авах эцсийн хугацаа нь: 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 10 цаг 00 минут
- (10.1) Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчид дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:
Ажлын байрны зохион байгуулалт.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрлөх явцад шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн сургалтанд хамруулж, мэргэжлийн эсвэл мэргэшсэн ур чадварын чадамж, мэргэжлийн зэрэг олгон ажилтны эрүүл мэнд хэвийн хадгалагдах, хөдөлмөрлөх чадвар нь өндөр түвшинд байхаар зохион байгуулсан байна.
 - Хөдөлмөрийн нөхцөл сөрөг хүчин зүйлийг арилгасан байх /хими, физик, биологийн болон биеийн хүчин зүйлээс шалтгаалан ажилтны бие махбодь, эрүүл мэнд өвчлөх, хөдөлмөрийн чадвар буурахаас урьдчилан сэргийлсэн байх/
 - Үйлдвэрлэл үйлчилгээний явцад техник, тоног төхөөрөмж, технологиос шалтгаалан ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт хохирол учруулж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.
 - Хувийн хамгаалах хэрэгслэлээр хангах боломжтой эсэх /ажлын хувцас, сонсох, амьсгалах эрхтний, хамгаалах хэрэгсэл/
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байраар хангах бизнес төсөл нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 3 дахь заалтын арга хэмжээ, бодлого, чиглэлд нийцсэн байна.
 - Төслийн хэрэгжилтийн хүрээнд ХБИ-ний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байртай болох хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх хамрагдана.

- Төслийн нийт өртөг, зардал, ашиг, орлогыг зах зээлийн ханшид үндэслэн бодитой тооцсон байна.
- Төслийн нийт тооцоот зардал, төсөлд олгох санхүүжилтийн дээд хязгаараас илүү гарсан бол уг зардлыг төсөл хэрэгжүүлэгч өөрөө хэрхэн хариуцахаа тооцоонд тусгасан байна. Үүнд мөнгөн болон мөнгөн бус биет хөрөнгө /газар, байр, тоног төхөөрөмж зэрэг/ байж болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлөөс 2022 онд хэрэгжүүлэх төслүүдийн тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдал нь давуу тал болно

Төслийн баримт бичигт дор дурьдсан материалыг хавсаргана.

Үүнд:

- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Төслийн үр дүнд байнгын ажлын байртай болох хөгжлийн бэрхшээлтэй иргэний оршин суугаа баг, хорооны тодорхойлолт,
- Иргэний үнэмлэх, эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хуулбар хувь /Хүчинтэй хугацаа нь дуусаагүй байх/
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн талаарх татварын алба, харилцагч банк, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт

БҮЛЭГ IV. ТӨСЛИЙН МАЯГТ, ЧАДВАРЫН МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Үйлчилгээ үзүүлэгчийн төсөл

Үйлчилгээ үзүүлэх төслийн маягт бөглөх санамж

Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч нь энэхүү төслийн маягтыг бөглөж төслийн материалын хамт ирүүлнэ. /Төслийн маягтыг төсөл сонгон шалгаруулалтад оролцогч байгууллага нь байгууллагынхаа албан бланкын маягт дээр бөглөж, тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулна./

[огноо]

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ТАМИР ТАНАА

- Бид, [төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр], танай гаргасан төслийн баримт бичгийг судалж үзээд [төслийн нэр ба дугаар]-ыг энэ төслийн баримт бичигт заасан гэрээний нөхцөл, үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт болон энэ төсөл сонгон шалгаруулалттай хамт санал болгож буй бизнес төлөвлөгөөний дагуу төсөл шалгаруулалтад оролцох [төслийн нэр], хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байрны тоо _____ үйлдвэрлэлийн төслийг хэрэгжүүлэхээр санал болгож байна.

№	төсөл сонгон шалгаруулалтад оролцох ажлын байрны нэр	Төслийн нэр үйл ажиллагааны, чиглэл	Нэг ажлын байранд ноогдох зардал /мян.төг/	Үүнээс			Тусгайлсан ажлын байрны тоо
				ХЭДС /мян.төг/ төслийн нийт дүн	ТББ, ААН-ийн оролцоо \ мян.төг\	Ажил олгогчийн оролцоо /мян.төг/	
1							
2							
3							
4							
5							
6							

- Энэ төсөл сонгон шалгаруулалт нь төслийн баримт бичигт шаардсаны дагуу ТСШӨХ-д заасан хугацаанд хүчинтэй гэдгийг бид үүгээр баталж байна.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү төслийн материал болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр: _____

Эрх бүхий этгээдийн гарын үсэг: _____

Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал : _____

Хаяг: _____

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ

Чадварын мэдээллийг бөглөх санамж

Гэрээг хэрэгжүүлэх чадвартайгаа нотлох, эсхүл урьдчилсан сонголтод ирүүлсэн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодотгох зорилгоор төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод өгөх зааварчилгааны 4 дүгээр зүйлд заасны дагуу төсөл сонгон шалгаруулалтад оролцогч дараах мэдээллийг бөглөж ирүүлнэ. Эдгээр мэдээлэл гэрээний хэсэг болохгүй. Шаардлагатай бол нэмэлт хуудас хэрэглэнэ. Хавсаргасан баримт бичиг нь төслийн материалыг бэлдсэн хэлнээс өөр хэл дээр бол түүнийг орчуулсан байх шаардлагатай. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч урьдчилсан сонголтод оролцсон бол зөвхөн өөрчлөгдсөн мэдээллээ бөглөж ирүүлнэ.

1. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч болон түншлэлийн гишүүн бүр
 - 1.1. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд болохыг нотлох баримт бичиг буюу улсын бүртгэлийн гэрчилгээ [хуулбарыг хавсаргах]
 Бүртгүүлсэн газар: [бөглөх]
 Үйл ажиллагааны үндсэн хаяг: [бөглөх]
 Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл: [хавсаргах]
 - 1.2. Сүүлийн 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн нийт мөнгөн дүнг мэргэжил тус бүрээр жагсаах: [бөглөх]
 - 1.3 Сүүлийн 1 жилийн хугацаанд ажиллуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо
 - 1.4 Төсөл сонгон шалгаруулалтад оролцох төслийг хэрэгжүүлэхээр санал болгож буй арга хэлбэр, шалгаруулалтын үзүүлэлтүүдийг хангах талаархи мэдээллийг ирүүлэх
 - 1.5. Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай тохируулгатай ажлын байр бий болгох эсвэл бий болгосон ажил үйлчилгээ үзүүлэх ажлын байр, талбай, үндсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр төрлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтээр ирүүлнэ.

Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр төрөл	Тодорхойлолт, үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа (жилээр)	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), ба тоо ширхэг	Өөрийн, түрээслэх (хаанаас?) эсхүл худалдаж авах (хаанаас?),
(a)			
(б)			

- 1.6. Гэрээнд санал болгож буй удирдах болон гүйцэтгэх /багш/ голлох мэргэжилтний чадвар, туршлага. Намтрыг хавсаргана.
- 1.7. Санхүүгийн чадавхийг харуулах 2020-2021 оны санхүүгийн тайлан
- 1.8. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн харилцагч банкны нэр, хаяг болон утас, телекс, факсын дугаар.

- 1.9. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн одоогийн ба сүүлийн 1 жилийн хугацаанд оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талууд ба нэхэмжлэлийн мөнгөн дүн, шийдэгдсэн байдал /Энэ талаархи мэдээллийг гаргаж ирүүлэх/

Нөгөө тал(ууд)	Маргааны шалтгаан	Шийдэгдсэн байдал	Нэхэмжлэлийн мөнгөн дүн
(a)			
(b)			

- 1.10. Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод өгөх зааварчилгааны 3.3-т заасан эрх бүхий төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн шаардлагыг хангаж байгаа тухай мэдэгдэл.
- 1.11. Санал болгож буй хөтөлбөр, төсөл (үйлчилгээний ажлын арга хэлбэр ба хуваарь). Төслийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгааг харуулах дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай бол зураг болон бүдүүвч график, үйл ажиллагааг хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөө

ХАВСРАЛТ

Төсөл хэрэгжүүлэх тодорхойлолт /Ажлын даалгавар/

1.1.Төслийн материалыг ХБХХЕГазар /20220906/ дугаартай төслийн баримт бичгийн дагуу бүрдүүлсэн байна.

- 1.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 1 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжийн бизнесээ өргөжүүлэх, шинээр тохируулгатай ажлын байр бий болгох тухай, мөн бусад аж ахуйн нэгжийн шинээр тохируулгатай ажлын байр бий болгож хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тогтвортой ажиллуулах тухай боловсруулсан төслийг шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, анх удаа орж байгаа бол 30.0 хүртэл сая төгрөгийг 36 сарын хугацаатай, гэрээний үүргээ биелүүлсэн давтан орж байгаа бол 50.0 хүртэл сая төгрөгийг 48 сарын хугацаатай санхүүгийн дэмжлэгийг 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгоно;
- 1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах чиглэлээр байнгын үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын боловсруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмшүүлэх зорилготой, төрийн бус байгууллагынхаа үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгож, тогтвортой ажиллуулах тухай төслийг сонгон шалгаруулж, барьцаагүй, хүүгүй 20 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийн эргэн төлөх нөхцөлтэйгөөр 36 сарын хугацаатайгаар олгоно.
- 1.4. Сүүлийн 24 сарын хугацаанд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага 2022 онд сонгон шалгаруулалтанд оролцох эрхгүй.
- 1.6. Төслийн баримт бичигт дор дурьдсан материалыг хавсаргана.

Үүнд:

Аж ахуйн нэгж байгууллагын төслийн баримт бичгийн бүрдүүлэлт:

- Сүүлийн гурван сарын дотор нотариатаар батлуулсан улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ;
- Байгууллагын танилцуулга;
- Харилцагч банкны тодорхойлолт;
- Банкны баталгаа;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт;
- Татвар, нийгмийн даатгалд өртэй эсэх тодорхойлолт;
- Батлагдсан тэргүүлэх чиглэлийн дагуу боловсруулсан төсөл;
- Удирдлагын бүтэц орон тоо, ажиллагсдын анкет;
- Төсөлд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн иргэний үнэмлэхний хуулбар, хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлох эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүчин төгөлдөр акт, /оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт/ хүн тус бүрээр ирүүлэх/;
- Ажлын байртай байх /түрээсийн гэрээ, өөрийн эзэмшлийн байртай бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, газар тариалангын төсөл бол газрын гэрчилгээ, түрээсийн гэрээг нотариатаар батлуулсан байх/;
- 2020, 2021 оны санхүүгийн жилийн эцсийн баталгаажсан тайлан;
- Баримт бичиг бүрэн байх /баримт бичиг дутуу төслийг эхний шатны сонгон шалгаруулалтаас хасна/;

Төсөлд тавигдах шаардлага:

- Төсөлд оролцогч байгууллага нь 1-ээс доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох бизнесийн төсөл нь зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нарийвчилсан төслийн тогтвортой байдлыг хангахуйц үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх;
- Сүүлийн 24 сарын хугацаанд хугацаанд төсөл, хөтөлбөрт хамрагдаагүй байх, аж ахуй нэгж байгууллагын удирдлагууд өөр байгууллагаар дамжуулан төсөлд хамрагдахгүй байх;
- Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ижил төстэй төслийн саналыг хүлээж авахгүй;
- Шинээр бий болгох тусгайлсан ажлын байрыг төлөвлөсөн байх;
- Төсөл хөтөлбөрт дахин хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын эргэн төлөлтийн мэдээ, ажлын байрны хадгалалт, үр дүнгийн тайлан зэргийг үндэслэх;

Төрийн бус байгууллагын төслийн баримт бичгийн бүрдүүлэлт:

- Сүүлийн гурван сарын дотор нотариатаар батлуулсан улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ;
- Байгууллагын танилцуулга;
- Харилцагч банкны тодорхойлолт;
- Банкны баталгаа;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт;
- Татвар, нийгмийн даатгалд өртэй эсэх тодорхойлолт;
- Батлагдсан тэргүүлэх чиглэлийн дагуу боловсруулсан төсөл;
- Удирдлагын бүтэц орон тоо, ажиллагсдын анкет;
- Төсөлд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн иргэний үнэмлэхний хуулбар, хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлох эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүчин төгөлдөр акт, /оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт/ хүн тус бүрээр ирүүлэх/;
- Ажлын байртай байх /түрээсийн гэрээ, өөрийн эзэмшлийн байртай бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, газар тариалангын төсөл бол газрын гэрчилгээ, түрээсийн гэрээг нотариатаар батлуулсан байх;/
- 2020, 2021 оны санхүүгийн жилийн эцсийн баталгаажсан тайлан;
- Баримт бичиг бүрэн байх /баримт бичиг дутуу төслийг эхний шатны сонгон шалгаруулалтаас хасна/;

Төсөлд тавигдах шаардлага:

- Төсөлд оролцогч байгууллага нь 1-ээс доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох бизнесийн төсөл нь зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нарийвчилсан төслийн тогтвортой байдлыг хангахуйц үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх;
- Сүүлийн 24 сарын хугацаанд хугацаанд төсөл, хөтөлбөрт хамрагдаагүй байх, төрийн бус байгууллагын удирдлагууд өөр байгууллагаар дамжуулан төсөлд хамрагдахгүй байх;
- Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хэрэгжүүлж буй төрийн бус байгууллагын ижил төстэй төслийн саналыг хүлээж авахгүй.
- Шинээр бий болгох тусгайлсан ажлын байрыг төлөвлөсөн байх;
- Төсөл хөтөлбөрт дахин хамрагдах төрийн бус байгууллагын ажлын байрны хадгалалт, үр дүнгийн тайлан зэргийг үндэслэх;

БҮЛЭГ VI. БАТАЛГААНЫ МАЯГТ

Хавсралт А Маягт:

Төслийн баталгаа (Банкны баталгаа) (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр] **Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар**

[Төсөл сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр] (цаашид “Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч” гэх) нь [Төсөл сонгон шалгаруулалтын нэр]-ийн ажлыг гүйцэтгэхээр төсөл (цаашид “Төслийн материал” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) Төсөл сонгон шалгаруулалтыг нээсний дараа төслийн маягтад заасан төсөл сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө оролцогч өөрийн төслийн материалыг буцааж авсан;
- (2) Захиалагч төсөл сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед төсөл сонгон шалгаруулалтад оролцогч:
 - (а) төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу төслийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) төсөл сонгон шалгаруулалтад оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн төслийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй банк нь төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь төсөл сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн дотор хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг _____

Албан тушаал, нэр _____

Банкны тамга

Огноо: _____

Хаяг: _____